

Хөршүүд

Хөршүүд

Энгийн чиглэлгүй N оройтой граф өгөгдсөн. Өөр лүүгээ орсон ирмэг байхгүй, мөн 2 оройн хооронд хамгийн ихдээ ганц ирмэг байдаг графыг энгийн граф гэнэ. Орой болгон дээр нэгэн эерэг тоо (≤ 500) өгөгдсөн. Нэг раундийн дараа орой болгон дээрх тоо дараах дүрмээр өөрчлөгдөнө:

Бүх хөршүүдийн өмнөх раундын тооны нийлбэр нь тухайн орой дээрх шинэ тоо болно.

Ирмэгээр холбогдсон бол хөрш гэж үзнэ.

Тэгвэл K раундийн дараах бүх орой дээрх тоог ол.

Оролт:

N, K - тоо

$N \times N$ A матриц өгөгдсөн. Хэрэв $A(i, j) = 1$ бол i болон j -ээр оройнууд ирмэгээр холбогдсон, үгүй бол $A(i, j) = 0$. Мөн үргэлж $A(i, j) = A(j, i)$ байна.

Нэг мөрөнд орой болгон дээр бичигдсэн тоо.

Гаралт:

Нэг мөрөнд зайгаар тусгаарлагдсан K -раундийн дараах N -ширхэг тоог ($10^9 + 7$) хуваагаад үлдэгдэл.

Хязгаарлалт:

$1 \leq N \leq 50$

$1 \leq K \leq 10^9$

Жишээ:

Оролт:

3 1

0 1 0

1 0 1

0 1 0

1 2 3

Гаралт:

2 4 2